



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 20

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын бэлтгэлийг хангуулах, бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Энхцэцэг (Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн)

Нарийн бичгийн дарга: Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд: Т.Үржинпүрэв (ХШҮДАХ-ийн дарга)


Ц.Удвал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Наранцэцэг (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Занданшарав: (Нийтлэг үйлчилгээний албаны компьютер, техник хангамжийн засвар үйлчилгээ хариуцсан ажилтан)

2. Мэргэшлийн шалгалтад анх орох иргэний бүртгэлийн холбогдох материалыг хүлээн авч, нягтлан шалгах, мэргэшлийн шалгалтын бүртгэлийг цахимаар хийх компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт авах байрны бэлтгэл, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг ажлын хэсэг (Н.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

03 - - 0039